**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2022/15/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он


Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Санал дүгнэлт
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....10
3. Аудитын тайлан ....10
3.1 Ерөнхий зүйл ....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....11
3.4 Материаллаг байдал ....11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....12
3.8 Аудитын гол асуудал ....14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....15
4. Аудитын илрүүлэлт....15
4.1 Залруулсан алдаа ....15
4.4 Зөвлөмж ....15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....17

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.24 № 14

танай____________-ны № _____________-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА
С.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт гаргах үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 320,114,712.45 | 367,700,055.35 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 320,114,712.45 | 367,700,055.35 |
| 351 | Түүхий эд материал | 186,981,219.75 | 197,913,766.65 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 185,609,219.75 | 195,863,516.65 |
| 35130 | Эм боох материал | 1,372,000.00 | 2,050,250.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 3,975,360.00 | 56,535,360.00 |
| 354 | Хангамжийн материал | 103,354,020.70 | 88,936,765.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 16,868,552.00 | 5,359,214.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,970,231.50 | 8,322,801.50 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,215,000.00 | 645,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,910,854.20 | 2,474,382.20 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,707,100.00 | 12,860,050.00 |
| 35460 | Хүнсний материал | 22,000.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 70,660,283.00 | 59,275,318.00 |
| 35600 | Мал амьтад | 25,804,112.00 | 24,314,163.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,488,773,694.89 | 2,889,880,811.03 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,488,773,694.89 | 2,889,880,811.03 |
| 392 | Биет хөрөнгө | 2,863,921,194.85 | 2,265,240,811.03 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,850,268,795.88 | 1,850,268,795.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -141,844,126.24 | -178,580,228.44 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 760,207,111.30 | 752,374,445.30 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -519,579,185.04 | -561,566,656.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,670,390,232.27 | 1,705,423,282.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -873,494,522.41 | -1,402,960,950.26 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 87,592,528.29 | 89,302,528.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -53,725,094.92 | -69,245,921.95 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 69,223,600.00 | 69,223,600.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 18,834,745.00 | 18,834,745.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,952,889.28 | -7,832,828.68 |
| 393 | Биет бус хөрөнгө | 624,852,500.04 | 624,640,000.00 |
| 39301 | Програм хангамж | 425,000.00 | 425,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -212,499.96 | -425,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 624,640,000.00 | 624,640,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,808,888,407.34 | 3,257,580,866.38 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,808,888,407.34 | 3,257,580,866.38 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,808,888,407.34 | 3,257,580,866.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,056,964,936.51 | 2,056,964,936.51 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,056,964,936.51 | 2,056,964,936.51 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 678,005,540.61 | 126,697,999.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 678,005,540.61 | 678,005,540.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -551,307,540.96 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,073,917,930.22 | 1,073,917,930.22 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,808,888,407.34 | 3,257,580,866.38 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 7,818,272,524.05 | 8,569,871,639.62 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,760,525,087.05 | 3,774,892,798.62 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,760,309,087.05 | 3,774,892,798.62 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,467,262,057.00 | 3,617,513,421.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,458,682,875.00 | 3,609,355,389.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,579,182.00 | 8,158,032.00 |
| 122 | Тусламжийн орлого | 216,000.00 | 00.00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 216,000.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,057,747,437.00 | 4,794,978,841.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,802,469,900.00 | 3,257,591,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,802,469,900.00 | 3,257,591,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,255,277,537.00 | 1,537,387,741.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,228,000.00 | 20,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,250,049,537.00 | 1,517,387,741.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 8,208,607,255.72 | 9,121,179,180.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 8,208,607,255.72 | 9,121,179,180.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,071,961,880.81 | 8,882,822,225.08 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6,857,480,016.00 | 7,507,409,931.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,276,627,364.89 | 1,544,986,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,679,228,015.00 | 3,322,763,714.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 483,702,171.00 | 415,267,805.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,417,922,465.11 | 2,224,391,612.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 156,510,071.40 | 172,941,149.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,654,925.11 | 1,721,115.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 144,855,146.29 | 171,220,034.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 63,712,627.19 | 67,622,783.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,522,549.00 | 21,265,419.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,260,226.19 | 29,489,702.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,929,852.00 | 16,867,662.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 218,799,270.99 | 257,469,247.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 30,276,408.99 | 20,052,697.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 153,319,555.00 | 150,997,924.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,469,463.00 | 13,883,367.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 710,000.00 | 710,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,503,060.00 | 8,532,150.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,520,784.00 | 63,293,109.60 |
| 2105 | Нормативт зардал | 47,690,673.00 | 27,030,170.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,850,673.00 | 723,450.00 |
| 210502 | Хоол, хүнс | 42,840,000.00 | 26,306,720.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 24,871,700.00 | 35,656,885.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,125,500.00 | 3,669,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,746,200.00 | 31,987,135.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,458,800.00 | 9,029,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,458,800.00 | 9,029,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 44,758,889.00 | 74,423,570.62 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,687,251.50 | 70,055,689.12 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 859,972.50 | 1,198,122.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 620,000.00 | 526,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 191,665.00 | 243,359.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 650,679,833.23 | 731,239,488.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 77,454,355.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,080,000.00 | 1,974,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 648,599,833.23 | 651,810,933.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 136,645,374.91 | 238,356,955.50 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 55,827,150.00 | 96,614,253.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 6,516,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 55,827,150.00 | 90,097,753.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 80,818,224.91 | 141,742,702.50 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 56,362,336.20 | 62,469,118.50 |
| 213304 | Хөрөнгийн | 24,455,888.71 | 79,273,584.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -390,334,731.67 | -551,307,540.96 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -390,334,731.67 | -551,307,540.96 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,056,964,936.51 | 1,073,917,930.22 | 1,068,340,272.28 | 4,199,223,139.01 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,056,964,936.51 | 1,073,917,930.22 | 1,068,340,272.28 | 4,199,223,139.01 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -390,334,731.67 | -390,334,731.67 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,056,964,936.51 | 1,073,917,930.22 | 678,005,540.61 | 3,808,888,407.34 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,056,964,936.51 | 1,073,917,930.22 | 678,005,540.61 | 3,808,888,407.34 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,056,964,936.51 | 1,073,917,930.22 | 678,005,540.61 | 3,808,888,407.34 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -551,307,540.96 | -551,307,540.96 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,056,964,936.51 | 1,073,917,930.22 | 126,697,999.65 | 3,257,580,866.38 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 7,516,620,330.00 | 8,404,334,230.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,458,812,647.00 | 3,609,355,389.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,458,812,647.00 | 3,609,355,389.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,458,812,647.00 | 3,609,355,389.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,458,812,647.00 | 3,609,355,389.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,057,807,683.00 | 4,794,978,841.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,802,469,900.00 | 3,257,591,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,802,469,900.00 | 3,257,591,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,255,337,783.00 | 1,537,387,741.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,228,000.00 | 20,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,250,109,783.00 | 1,517,387,741.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 7,509,945,330.00 | 8,404,334,230.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 7,509,945,330.00 | 8,404,334,230.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 7,373,439,070.09 | 8,166,645,824.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6,857,809,147.11 | 7,578,351,367.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,276,893,711.00 | 1,544,986,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,679,290,800.00 | 3,323,179,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 483,702,171.00 | 415,267,805.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,417,922,465.11 | 2,294,917,062.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 156,510,073.29 | 172,941,149.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,654,927.00 | 1,721,115.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 144,855,146.29 | 171,220,034.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 65,212,627.19 | 69,215,702.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,522,549.00 | 22,650,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 29,760,226.19 | 29,219,702.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,929,852.00 | 17,345,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 169,338,550.00 | 165,234,759.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 20,773,000.00 | 16,552,792.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 130,946,600.00 | 129,750,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,484,950.00 | 13,883,367.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 104,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 710,000.00 | 710,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,424,000.00 | 4,234,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 44,814,800.00 | 28,547,720.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,202,800.00 | 765,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 42,862,000.00 | 26,289,720.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 750,000.00 | 1,493,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 32,323,100.00 | 58,456,605.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 14,740,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,000,000.00 | 3,996,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 28,323,100.00 | 39,719,805.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,458,800.00 | 9,029,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,458,800.00 | 9,029,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,891,972.50 | 82,369,522.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,012,000.00 | 77,745,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 859,972.50 | 1,698,122.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 620,000.00 | 526,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,080,000.00 | 2,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,080,000.00 | 2,500,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 136,506,259.91 | 237,688,405.50 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 55,688,035.00 | 95,945,703.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 5,900,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 55,688,035.00 | 90,044,803.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 80,818,224.91 | 141,742,702.50 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 56,362,336.20 | 62,469,118.50 |
| 213304 | Хөрөнгийн | 24,455,888.71 | 79,273,584.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 6,675,000.00 | 00.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 6,675,000.00 | 00.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6,675,000.00 | 00.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6,675,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,675,000.00 | 00.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -6,675,000.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,805,901,800.00 | 6,804,477,370.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,805,901,800.00 | 6,804,477,370.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,785,520,900.00 | 6,784,104,042.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 6,399,208,100.00 | 6,399,208,100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,544,986,800.00 | 1,544,986,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 3,317,179,700.00 | 3,323,179,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,537,041,600.00 | 1,531,041,600.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 75,683,500.00 | 75,206,334.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 75,683,500.00 | 75,206,334.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 69,544,700.00 | 69,215,702.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,650,500.00 | 22,650,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 29,463,900.00 | 29,219,702.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 17,430,300.00 | 17,345,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 140,773,600.00 | 140,753,059.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,483,000.00 | 14,479,092.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 108,590,600.00 | 108,590,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,446,000.00 | 13,445,367.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 104,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 710,000.00 | 710,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,424,000.00 | 3,424,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 25,752,000.00 | 25,410,720.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,000.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 23,952,000.00 | 23,617,720.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,493,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 47,660,000.00 | 47,656,605.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,940,000.00 | 3,940,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,000,000.00 | 3,996,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 39,720,000.00 | 39,719,805.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,029,000.00 | 9,029,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,029,000.00 | 9,029,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,370,000.00 | 15,124,522.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,500,000.00 | 10,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,850,000.00 | 1,698,122.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 620,000.00 | 526,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2500000.00 | 2500000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20380900.00 | 20373328.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20,380,900.00 | 20,373,328.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,900,900.00 | 5,900,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,480,000.00 | 14,472,428.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 6,805,901,800.00 | 6,804,477,370.50 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,257,591,100.00 | 3,195,121,981.50 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,257,591,100.00 | 3,195,121,981.50 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 3,548,310,700.00 | 3,609,355,389.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,548,310,700.00 | 3,609,355,389.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 1,020.00 | 58,301.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 555.00 | 7,878.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 455.00 | 4,545.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 45,878.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,230,881,894.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,230,881,894.29 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,181,453,859.29 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,074,983,946.00 |
| 210101 | Үндсэн цалин | 149,933,609.00 |
| 210104 | Урамшуулал | 483,702,171.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 441,348,166.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,967,613.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,654,927.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,312,686.29 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 31,434,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,850,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,356,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,228,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 7,089,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 79,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,010,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,678,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,678,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,300,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,300,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49428035.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 49,428,035.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 49,428,035.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1255337783.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,255,337,783.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,228,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,250,109,783.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 38/704 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймаг дахь Цагдаагийн газар нь нь Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах үүрэг бүхий Цагдаагийн Ерөнхий Газрын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын  2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 6,805,901.8 мянган

төгрөгөөс 1.0 хувиар буюу 68,059.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 47,641.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 551,307.5 мянган төгрөгөөр буюу 14.47 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 320,114.7 | 367,700.05 | 47,585.35 |
| Үндсэн хөрөнгө | 3,488,773.7 | 2,889,880.8 | (589,892.9) |
| **Нийт хөрөнгө** | **3,808,888.4** | **3,257,580.9** | **(551,307.5)** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,808,888.4 | 3,257,580.9 | (551,307.5) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3,808,888.4** | **3,257,580.9** | **(551,307.5)** |

Бараа материалын данс 367,700.05 мянган төгрөг болж 47,585.35 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал, бэлэн бүтээгдэхүүний дансны үлдэгдэл ихэссэнээс шалтгаалсан байна. Энэ нь Цагдаагийн ерөнхий газраас шилжүүлгээр ирсэн тусгай зориулалтын материал хэрэгслийг бараа материал дансанд орлого авч үлдэгдлээр үлдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,889,880.8 мянган төгрөг болж 589,892.9 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөж үлдэх өртөггүй болсон цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг хоёр жилээр сунгасан нь элэгдлийн зардлыг өсгөсөн байна. Тээврийн хэрэгсэл данснаас 24,007.6 мянган төгрөгийн авто машин акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,257,580.9 мянган төгрөг болж 551,307.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 751,599.1 мянган төгрөгөөр буюу 9,6 хувиар, нийт зардал өмнөх оноос 912,571.9 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар тус тус өссөн байна.

Орхон аймаг дахь Цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын санхүү, аж ахуйн албаны даргын 2020 оны 12 дугаар сарын 25-ний өдөр баталсан 2021 оны төсвийн төлөвлөгөөний дагуу үндсэн үйл ажиллагааны орлого 3,548,310.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс, гэрээт байгууллага “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 3,518,729.7 мянган төгрөг, Монгол банкнаас 65,960.0 мянган төгрөг, бусад үйл ажиллагааны орлого 24,665.6 мянган төгрөг нийт 3,609,355.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймаг дахь Цагдаагийн газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,866,946.5 мянган төгрөгөөр төлөвлөн, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 3,111,045.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,548,310.7 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, улсын төсвөөс 3,111,045.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 3,609,355.4 мянган төгрөгийн орлого олж, урсгал зардалд нийт 6,804,477.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,804,477.3 мянган төгрөг буюу цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 6,399,208.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 75,206.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлалд 69,215.7 мянган төгрөг, хангамжийн материалын зардалд 140,753.1 мянган төгрөг, норматив зардал 25,410.7 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 47,656.6 мянган төгрөг, томилолт зочны зардал 9,029.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 15,124.5 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 2,500.0 мянган төгрөг зарцуулсан ба хэмнэгдсэн зардал болон давж биелсэн үндсэн үйл ажиллагааны орлого болох нийт 62,469.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд гэрээт байгууллага болох “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 1,296,711.6 мянган төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас олон нийтийн цагдаагийн урамшуулал 133,540.2 мянган төгрөг , бусад төсөл хөтөлбөрөөс 41,500.0 мянган төгрөг, АИТХ-аас төсөл хөтөлбөрийн 19,832.0 мянган төгрөг, Эрдэнэт сангаас 20,000.0 мянган төгрөг, бусад үйл ажиллагааны орлого 28,383.8 мянган төгрөг нийт 1,539,967.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс гэрээт байгууллагын цалин урамшуулалд 1,179,143.3 мянган төгрөг НДШ-ийн зардалд 104,161.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 24,481.7 мянган төгрөг, норматив зардал 3,137.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 10,800.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 67,245.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 75,572.4 мянган төгрөг бусад

2,580.0 мянган төгрөг зарцуулж, улсын төсөвт 79,273.6 мянган төгрөгийн хэмнэлтийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймаг дахь Цагдаагийн газар нь 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүрэн мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 34.3.2-д “тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй”, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.4-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт

өртгийг үндэслэл болгоно", 19.2-д "тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана", 47.7-д "үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид "үнэлгээний дүгнэлт" гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна", 14.1-д "дараахь нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ", 46.1.1-д "энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах" 46.1.2-д "үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 598.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж, 598.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Зөвлөмж | 2 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| Төлбөрийн акт | 2 | 598.3 | 2 | 598.3 | | | |
| Нийт дүн | 4 | 598.3 | 4 | 598.3 | 0 | 0 | 0 |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 88,808.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 77,454.3 мянган төгрөгийн алдааг залруулж 11,354.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүнгийн тайланд 77,454.3 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэнийг залруулав.

**4.2 Төлбөрийн акт** Байхгүй.

**4.3 Албан шаардлага** Байхгүй.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал***

***1.1. <u>Илрүүлэлт:</u>***

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 4,466.3 мянган төгрөгийн дутуу баримтаар гүйлгээ хийсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах. Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

***1.3. <u>Илрүүлэлт:</u>***

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийг шилжүүлэхдээ гэрээ хэлцэл хийлгүй 6,887.9 мянган төгрөгийг шилжүүлсэн /МСДОС ХХК, Баясгалант хангай ХХК, иргэн Хүрэлбаатар/ байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 34.3.2-д "тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*1.4. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн зарцуулалтын үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс ажил үйлчилгээ авахдаа гэрээ байгуулах.

***1.5. <u>Илрүүлэлт:</u>***

Шатах тослох материал зарлагадахдаа НХМаягт БМ-6 маягт ашигладаггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

*1.6. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Шатахуун, шатах тослох материалын зарцуулалтад анхан шатны маягтыг бүрэн хөтөлж, баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангасан нөхцөлд зарлага гаргаж, санхүүгийн тайланд тусгах.

***1.7. <u>Илрүүлэлт:</u>***

Шатах тослох материалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа хуулийн зарим заалтыг зөрчсөн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.4-д "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 19.2-д "тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана", 47.7-д "үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид "үнэлгээний дүгнэлт" гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан

байна", 14.1-д "дараахь нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ", 46.1.1-д "энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах" 46.1.2-д "үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*1.8. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай, хариуцлагатай зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Орхон аймаг дахь Цагдаагийн газар | 5 | 88,808.6 | 1 | 77,454.3 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 11,354.3 |